| 2.3.2.9 | Арга хэмжээ: Сургууль бүрд байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах | 2021-2024 | ОНТ 10.3 сая | Байгуулсан кабинетын тоо | 2022 | 9 | 16 | 2023 оны хичээлийн жилд Дэрэн сумын сургууль химийн хичээлийн татах шүүгээг авч хичээл сургалтдаа ашиглаж байна. Мөн Цэгц билиг, Дэлгэрцогт сумын сургуулиуд байгалийн ухааны кабинеттай болохоор хэрэглэгдэхүүн, бичиг | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баримтын бэлтгэлээ хангаж ажиллаж байна. Сайхан овоо сумын байгалийн ухааны багш сургууль орон нутаг хөгжүүлэх санд төсөл бичин өгсөн байгаа. Эдгээр кабинетууд ашиглалтад орсноор 14 сургууль байгалийн ухааны кабинеттай болно. | |
| 2.3.2.10 | <u>Арга хэмжээ</u>: Сургууль, дотуур байрыг 100% шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгох | 2021-2024 | | Дотор нойлтой сургуулийн тоо | 2022 | 15 | 17 | 19 сургуулийн 18 буюу 95 хувь нь дотор нойлтой байна. | 85 |
| | | 2021-2024 | УТ 1.0 сая | Дотор нойлтой дотуур байрны тоо | 2022 | 14 | 16 | 17 дотуур байрны 14 буюу 82 хувь дотор нойлтой байна. | |
| | | 2021-2024 | | Усанд орох нөхцөл бүрдсэн дотуур байрны тоо | 2022 | 15 | 17 | 17 дотуур байрны 14 буюу 82 хувь усанд орох нөхцөл бүрдсэн. | |
| 2.3.2.11 | <u>Арга хэмжээ</u>: Цэцэрлэг, сургууль, дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулах | 2021-2024 | | камертай сургууль, цэцэрлэг, дотуур байрны эзлэх хувь | 2022 | 70 | 80 | Салбарын 58 барилга байгууламжаас 2022 онд 18 сургууль, 17 дотуур байр, 20 цэцэрлэгийг 200 сая төгрөгөөр бүрэн камержуулсан нь сургалтын үйл ажиллагаа болон хүүхэд хамгаалал, ёс зүйн асуудлыг камераар хянах нөхцөл бүрдсэн арга хэмжээ болов. | 100 |
| 2.3.2.11 | Арга хэмжээ: "Дундговь-боловсролын чанар" төсөл хэрэгжүүлэх | 2021-2024 | ОНТ 150.0 сая | Хэрэгжилтийн хувь | 2022 | | 100 | Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багш нарын багийг урамшуулах тухай удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулж шаардагдах 150,0 сая төгрөгийг | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баталсан. Төслийн хүрээнд МУБИС, Оюунлаг сургуулиудтай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж, дээрх сургуулиудаас дунд ахлах ангийн багш нарыг онол арга зүйг дээшлүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 340 багш хамрагдлаа. 12 дугаар ангийн төгсөж байгаа 370 сурагчдыг " Гранд Ай Ти компанийн "ЭЕШ-800" дата анализын программыг ашиглан 3 удаагийн сорилыг авч, дүгнэлт хийн ажиллаж байна. Мөн Оюунлаг сургуультай хамтран 1 удаа цахим, 2 удаагийн цаасаар шалгалтад бэлтгэх урьдчилсан сорилуудыг зохион байгуулж, багш нар хүүхэд бүрийн алдаан дээр тулгуурлан, сургалт давтлага хийх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 2.3.3.1 | <u>Зорилт:</u> МСҮТөвийг Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, төгсөгчдийн ажил эрхлэлт 2020 онд 65 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ. | 2021-2024 | | Ажил эрхлэлтийн хувь | 2022 | 68 | 69 | Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгааг 6, 12-р сард авдаг бөгөөд 2022 оны судалгааны дүнгээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 83.2 хувьтай байна. | 100 |
| 2.3.3.2 | <u>Арга хэмжээ</u>: Багшлах бүрэлдэхүүний боловсролын зэргийг ахиулан магистрын сургалтад хамруулах | 2021-2024 | Хувийн хэвшил 6.0 сая | Магистрын зэрэгтэй багшийн тоо | 2022 | 17 | 19 | 2022-2023 оны хичээлийн жилд 18 багш буюу нийт багш нарын 51.4% нь магистр зэрэгтэй байна.<br>Энэ хичээлийн жилд 4 багшийг шинээр магистрын сургалтад хамруулж байна. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.3.3 | Арга хэмжээ: Техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг барилга болон хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр боловсруулж, дүгнэлт гаргуулах | 2022-2023 | | Гарсан дүгнэлтийн тоо | 2022 | 1 | 1 | Барилга угсралтын техникч, малын бага эмч, зоотехникч мэргэжлийн Техникийн боловсрол олгох сургалтын 3 хөтөлбөрийг боловсруулж, МБСҮМАЗТ-өөр дүгнэлт гаргуулсан. Техникийн боловсрол олгох 4 мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. | 100 |
| 2.3.3.4 | Арга хэмжээ: Хөдөө аж ахуйн мэргэжлийн кабинетыг байгуулах | 2022-2023 | УТ 4.0 сая | Байгуулсан кабинетын тоо | 2022 | 1 | 0 | Хөдөө аж ахуйн мэргэжлийн 1 кабинетыг шинээр байгуулж, 4.000.000 төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн. Мөн малын бага эмч, зоотехникч мэргэжлийн лаборатори байгуулах төсөл боловсруулан холбогдох газруудад хүргүүлээд байна. | 100 |
| | **2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал** | | | | | | | | |
| 2.4 | Зорилго: Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 74.8 хувь байсныг 2024 онд 77.2 хувьд хүргэнэ. | 2021-2024 | | Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь) | 2022 | 76 | 76.6 | 2022 оны IV дүгээр улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 71,1 хувьтай байна. | - |
| 2.4.1 | Зорилт: Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсныг 2024 онд 12218-д хүргэнэ. | 2021-2024 | | Нийгмийн даатгалд даатгуулсан иргэдийн тоо | 2022 | 11658 | 11888 | 5 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалд 8615 даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс заавал даатгуулагч 5839, сайн дурын даатгуулагч 2776 байна. 2023 оны жилийн эцэст хүрэх түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.1.1 | Арга хэмжээ: Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021-2024 | | Иргэдэд үзүүлсэн байх үйлчилгээний тоо | 2022 | 7 | 8 | Тус хэлтэс нь жирэмсэн болон амаржсаны тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл гаргах, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл гаргах, ажилгүйдлийн тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл гаргах, шимтгэлийн тайлан илгээх, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, Иргэд даатгуулагч нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа, Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, Нийгмийн даатгалын сангаас авдаг тэтгэврийн талаарх лавлагаа, тодорхойлолт, тэтгэвэр өөрчлөн тогтоолгох цахим архивын QR кодтой лавлагаа, төрийн сангийн гүйлгээ зэрэг 14 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлэн иргэд даатгуулагч нарт үйлчилгээ үзүүлж байна. | 100 |
| 2.4.1.2 | Арга хэмжээ: Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлэх | 2021-2024 | | Цахимаар үйлчилгээ авч байгаа иргэдийн хувь | 2022 | 25 | 30 | 2023 оны 5 сарын байдлаар нийгмийн даатгалын цахим үйлчилгээнд 8285 тэтгэвэр авагч, 5824 заавал даатгуулагч, 360 хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 240 жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авагч, 138 цахим лавлагаа, 2776 сайн дурын даатгуулагч нийт 17623 даатгуулагч цахимаар үйлчилгээ авсан байна. Энэ нь нийт иргэдийн 41.9% хувь цахимаар үйлчилгээ авсан байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.2 | Зорилт: 2019 оны байдлаар ажиллаж байгаа 22040 иргэний байнгын ажлын байрыг 2200-р нэмэгдүүлнэ. | 2021-2024 | | Тухайн жилд ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 2022 | 487 | 667 | 5 дугаар сарын байдлаар ажлын байрны захиалгын дагуу 195 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна. | 30 |
| 2.4.2.1 | Арга хэмжээ: Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байранд зуучилж, бүртгэлжүүлэн, ажлын байртай болгох | 2021-2024 | | Тухайн жилд байнгын ажлын байраар хангагдсан хүний тоо | 2022 | 35 | 115 | Жижиг зээлд 1 аж ахуй нэгж, 5 иргэнд 100 сая төгрөг , ахмадын санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдсан 25 иргэнд 125 сая төгрөг, нийт 30 иргэнд 225 сая төгрөг зарцуулсан. | 30 |
| 2.4.2.2 | Арга хэмжээ: 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах | 2021-2024 | | Тухайн жилд ажлын байранд зуучилсан иргэний тоо | 2022 | 52 | 52 | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны ажилгүй 154 иргэний судалгааг гаргаж эхний 4 сарын байдлаар 19 иргэнийг ажлын байранд зуучлаад байна. | 30 |
| 2.4.2.3 | Арга хэмжээ: Түр ажлын байранд иргэдийг зуучилж ажлын байртай болгох | 2021-2024 | | Тухайн жилд ажлын байранд зуучилсан иргэний тоо | 2022 | 400 | 500 | Нийтийг хамарсан ажил, ногоон ажлын байр арга хэмжээгээр 41 иргэн түр ажлын байраар хангагдаж 14,7 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, 246,000 төгрөгийн ХАБЭА-н хэрэгсэл олгосон. | 10 |
| 2.4.3 | Зорилт Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага 2019 онд 24 байсныг 2024 онд 36-д хүргэнэ. | 2021-2024 | | Ахмадад ээлтэй сум, баг, байгууллагын тоо | 2022 | 30 | 33 | Аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 09-ний А/90 тоот захирамжаар батлагдсан “Ахмад ээлтэй сум, баг, байгууллага“ шалгаруулах журмын дагуу болзол хангасан УЦУОШТ, Өндөршил, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын цэцэрлэг, Эрдэнэдалай сумын Сангийн далай баг, Сайнцагаан сумын Аривжих баг шалгарч аймгийн хэмжээнд “Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага” 38 боллоо. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.3.1 | Арга хэмжээ: Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд тогтмол хамруулах | 2021-2024 | | Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ оношилгоонд хамрагдсан ахмад настны эзлэх хувь | 2022 | 45 | 50 | Оны эхний 5 сарын байдлаар давхардсан тоогоор 2950 ахмадуудыг үзлэг оношилгоо хамруулж 210 ахмадад өдрийн эмчилгээ хийж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүллээ. | 95 |
| 2.4.3.2 | Арга хэмжээ: Ахмад настнуудыг нас, бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах | 2021-2024 | | Алхалт, дасгал хөдөлгөөнд хамрагдсан ахмад настны тоо | 2022 | 1335 | 1385 | Ахмадууд нас биеийн онцлогт тохирсон спортын төрөл софт теннис, волейболын спортыг сурталчлах зорилгоор сум бүрд софт теннис, волейболын багтай болсон нь ахмадын эрүүл мэндэд үр дүнгээ өгч байна.<br>1541 ахмад настан алхалт, дасгал хөдөлгөөнд тогтмол хамрагдаж 31 ахмад унадаг дугуйгаар тогтмол дасгал хөдөлгөөнд оролцож байна.<br>Цэнгээнт бүжгийн сургалтад 112 ахмадууд хамрагдсан. | 100 |
| 2.4.3.3 | Арга хэмжээ: Аймгийн ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулах | 2021-2024 | | Бага наадамд оролцсон ахмад настны тоо | 2022 | 135 | 140 | Ахмадын урлагийн 8 дугаар бага наадмаа 2023 оны 05 сарын 28 -нд Мандалговь хотод зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулж, удирдамжаа батлуулж бүх сумдад хүргэж бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 90 |
| 2.4.4 | Зорилт: Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг 2019 онд 51 хувь байсныг 2024 онд аймгийн нийт хүүхдийн 59 хувьд хүргэнэ. | 2021-2024 | | Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь | 2022 | 55 | 57 | Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр 6 төрлийн урьдчилан сэргийлэх, нөлөөлөл, хамгааллын хариу үйлчилгээг зохион байгуулж 1340 хүүхэд буюу нийт 16752 хүүхдийн 8%-д хүрч ажиллалаа. | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.4.1 | Арга хэмжээ: Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 65-аас доошгүй хувийг чадваржуулах сургалтад хамруулах | 2021-2024 | | Сургалтад хамрагдсан үүрэг хүлээгчдийн хувь | 2022 | 45 | 55 | Агентлагийн даргын 2023 оны А/33 тоот тушаалын дагуу "Нийгмийн бүлгүүдийн өмнө үүрэг хүлээгчид, салбарын албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах нь" сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Хугацаа болоогүй. | - |
| 2.4.4.2 | Арга хэмжээ: “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд дээвэр, халуун ус, ариун цэврийн шинэ байгууламж, сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах | 2022-2023 | | Ашиглалтад орсон байгууламжийн тоо | 2022 | 2 | 5 | Төсөв шийдэгдээгүй. | - |
| 2.4.4.3 | Арга хэмжээ: Хүүхдийн паркийг стандартын дагуу орчин үеийн тоглоомтой болгох | 2022-2024 | ОНТ 90.8 сая | Шинээр ашиглалтад орсон тоглоомын тоо | 2022 | 1 | 4 | 2022 онд орон нутгийн санхүүжилтээр 90,8 сая төгрөгийн үнэ бүхий 4 төрлийн 11 ширхэг тоглоомыг шинээр авч, ашиглалтад оруулсан. | 100 |
| 2.4.4.4 | Арга хэмжээ: Хүүхдийн паркийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл шинээр хийх | 2023 | ОНТ 20 сая | Шинээр ашиглалтад орсон гэрэлтүүлгийн тоо | 2022 | | 84 | Хүүхдийн паркт 2023 онд сум хөгжүүлэх сангаас 20 сая төгрөгийн үнэ бүхий 5 төрлийн 86 ширхэг гэрэлтүүлгийг худалдан авахаар "Мандал шилтгээн" ХХК-тай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна. | 30 |
| 2.4.4.5 | Арга хэмжээ: Түр хамгаалах байртай болох | 2023 | | Түр хамгаалах байртай болсон эсэх | 2022 | | 1 | Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 250,000,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий “Түр хамгаалах | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | /тийм-1, үгүй-0/ | | | | байр бий болгох” саналыг батлуулж, тендерийн сонгон шалгаруулалт явагдаж байна. | |
| 2.4.5 | <u>Зорилт:</u> Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын дундаж хувь 2019 онд 22.3 байсныг 2024 онд 45 хувьд хүргэнэ | 2021-2024 | | Төвөөр үйлчлүүлсэн залуучуудын хувь | 2022 | 35 | 40 | Залуучууд хөгжлийн төвийн үйлчилгээг 5 дугаар сарын байдлаар 2755 буюу нийт залуучуудын 20 хувьд хүргэсэн байна.<br>Тус арга хэмжээнд 4,769,750 төгрөг зарцуулсан. | 50 |
| 2.4.5.1 | <u>Арга хэмжээ:</u> Залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх | 2021-2024 | | Тухайн жилд үйлчилгээнд хамрагдсан залуучуудын тоо | 2022 | 5000 | 5500 | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хүрээнд албадлагын арга хэмжээ авагдсан 6 хүүхэд, хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан 2 иргэнд амьдрах ухааны модуль сургалт, архины хамааралтай 3 залуу гэр бүлд сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Залуучуудыг соён гэгээрүүлэх, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 9 удаагийн арга хэмжээгээр 1505 иргэнд танхимын сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан. Цахим контент бэлтгэн байгууллагын цахим хуудас байршуулж нийт 1200 хүнд хүрсэн байна. 2023 оны 5 сарын байдлаар нийт 2705 залуучуудад хүрч ажилласан байна. | 50 |
| 2.4.5.2 | <u>Арга хэмжээ:</u>Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх | 2023-2024 | | Хуралдааны тоо | 2022 | | 2 | Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн гишүүн байгууллагаас 2023 оны үйл төлөвлөгөөний саналыг авч нэгтгэсэн. | - |
| | | | | Салбар зөвлөлийн | 2022 | | 80 | Төлөвлөгөө батлагдаагүй. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь | | | | | |
| 2.4.5.2 | <u>Арга хэмжээ:</u> Залуучуудыг хариуцлагатай иргэн болоход нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулах | 2022-2024 | - | Тухайн жилд зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2022 | 2 | 3 | Хугацаа болоогүй | - |
| | | | | Үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо | 2022 | 150 | 200 | | |
| 2.4.6 | <u>Зорилт</u>: Иргэд, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | | Сургалт, сурталчилгааны тоо | 2022 | 1 | 2 | Монголын ХАБЭА-н мэргэшсэн ажилтны үндэсний нийгэмлэг (НҮ ТББ)-ийн ерөнхийлөгч (PH.D) Б.Довдонбалжир багштай хамтран Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл, хөдөлмөрийн зуучлагч, арбитр, сумдын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, ААНБ-н ХАБЭА-н ажилтан, зөвлөлийг гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулж нийт 17 аж ахуй нэгж байгууллагуудын 60 албан хаагчид хамрагдаж хуулийн мэдлэгээ дээшлүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн олон улсын чиг хандлага, туршлага, сургамж, аймаг сумдын зөвлөлийн чиг үүрэг, анхаарах асуудлаар дэлгэрэнгүй | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэдээлэл өгч арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, 7 сая төгрөг зарцуулаад байна. | |
| 2.4.6.1 | Арга хэмжээ: Ослыг тэглэе" тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх | 2021-2024 | | Арга хэмжээний тоо | 2022 | | 1 | Хугацаа болоогүй. | - |
| 2.4.6.2 | Арга хэмжээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг зохион байгуулах | 2021-2024 | | Зохион байгуулсан үзлэгийн тоо | 2022 | 1 | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу мэргэжлийн боловсролын байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж 2023 оны 5 дугаар сарын 23-наас 6 дугаар сарын 3-н хүртэл зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 50 |
| 2.4.7 | Зорилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | | Зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2022 | 3 | 4 | Аймгийн салбар зөвлөлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд бичгийн спортыг сурталчлах зорилгоор "Бичгийн аймгийн аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд 2 насны ангиллаар 14 баг тамирчин оролцож насны ангилал тус бүр 1, 2, 3 дугаар байр шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан. Тэмцээнд шагналт байранд шалгарсан тамирчин нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд 4-р байр, Монголын хүүхдийн спортын VII наадам, Хан-Уул дүүргийн тэмцээнд хүрэл медаль авсан амжилтуудыг тус тус үзүүлээд байна. | 25 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.7.1 | Арга хэмжээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулган, спортын арга хэмжээ зохион байгуулах | 2022-2024 | | Арга хэмжээний тоо | 2022 | 1 | 1 | Хугацаа болоогүй 11 сард зохион байгуулна. | - |
| 2.4.7.2 | Арга хэмжээ: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг шинээр барьж ашиглалтад оруулах | 2022-2024 | | Гүйцэтгэлийн хувь | 2022 | 30 | 60 | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хамтарсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан суманд баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгыг хүлээн авах улсын комиссыг Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2022 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс томилох тухай" А/57 дугаар тушаалаар байгуулж барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ажилласан.<br>Комиссын бүрэлдэхүүнд захиалагч талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, хөрөнгө оруулагч талаас Азийн хөгжлийн банкны төслийн нэгж, зураг төсөл зохиогч “ЭМ ЭС ЭЛ” ХХК-ны төлөөлөл , гүйцэтгэгч талаас Ц.Ганзориг захиралтай “Хөх хайрхан трейд" ХХК-ны төлөөлөл, ашиглагч талаас ХХҮГ болон аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ХБ-тэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага зэрэг барилга хүлээж авах комиссын бүрэлдэхүүн барилгыг хүлээн аваад байгаа бөгөөд одоогоор боловсон | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүчний томилгоо хийгдэж үйл ажиллагаа эхлээгүй байгаа болно. | |
| | **2.5 Үндэсний бахархал, өв соёл** | | | | | | | | |
| 2.5 | Зорилго: Иргэдийг соён гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 2019 онд 294454 байсныг 2024 онд 37120-оор нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ОНТ УТ 1.5 | Соёл, урлагийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 2022 | 313014 | 322294 | Соёл, урлагийн байгууллагууд монгол өв соёлыг сурталчлан таниулах 32, урлаг уран бүтээлийн чиглэлээр 12, нийт 44 арга хэмжээг зохион байгуулж 81346 иргэдэд үйлчилгээ үзүүллээ. | 100 |
| 2.5.1 | Зорилт: Соёл, урлагийн салбарын насжилт өндөртэй барилга байгууламжийн тоо 2020 онд 14 байгааг 2024 онд 64.2 хувиар бууруулна. | 2021-2024 | ОНТ, УТ 507.4 | Тухайн жилд шинээр баригдаж буй барилгуудын гүйцэтгэлийн дундаж хувь | 2022 | 70 | 80 | Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч Хэрмээдэй ХХК нь төсөвт өртөг 1,523.4 сая төгрөг, тайлант хугацаанд гүйцэтгэлээр 709,669.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон. Барилгын ажлын гүйцэтгэл 63 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч ОДДА ХХК нь төсөвт өртөг 1,429.25 сая төгрөг, тайлант хугацаанд 780.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрдэнэдалай, Өлзийт сумдын соёлын төвийн барилга 2022 онд ашиглалтад орсноор насжилт өндөр барилга 14.3 хувиар буурсан байна. | 89.3 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.1.1 | <u>Арга хэмжээ:</u> Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилгын ажлыг үргэлжлүүлэх | 2021-2024 | УТ 671.7 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 2022 | 30 | 50 | Соёлын яамнаас 2 удаа цахим хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Хэлэлцүүлгээр ТХДЖТ барилгын ажлыг хуучин суурь дээр үргэлжлүүлэн барих, зураг төсвийг дахин шинэчлэн гаргахад шаардагдах хөрөнгө 250.0 сая төгрөгийн 50.0 сая төгрөгийг аймаг орон нутаг шийдвэрлэхээр үлдсэн төсвийг сайдын багцаас шийдвэрлүүлэхээр хэлэлцсэн. | - |
| 2.5.1.4 | <u>Арга хэмжээ:</u> Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах | 2021-2024 | УТ 1.5 | Шинээр баригдаж буй барилгуудын гүйцэтгэлийн дундаж хувь | 2022 | 70 | 80 | Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч Хэрмээдэй ХХК нь төсөвт өртөг 1,523.4 сая төгрөг, тайлант хугацаанд гүйцэтгэлээр 709,669.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон. 1,2 давхрын дотор өрлөгийн ажил хийгдэж дууссан. Дотор засал, шаврын ажил эхлэх гэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 63 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч ОДДА ХХК нь төсөвт өртөг 1,429.25 сая төгрөг, тайлант хугацаанд 780.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Барилгын өрлөгийн ажил дууссан. Гадна тохижилт, дотор заслын ажил хийгдэж, гүйцэтгэл 80 хувьтай байна. | 89.3 |
| 2.5.2 | <u>Зорилт:</u> Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 49.4 байгааг 2024 онд 51.7 хувьд хүргэнэ. | 2021-2024 | ОНТ, УТ 153.8 | Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь | 2022 | 50 | 51.1 | Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны батлагдсан орон тоо 138 үүнээс 2023 оны эхний хагас жилийн байдлаар 58,6 хувь буюу 81 ажилтантай. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.2.1 | <u>Арга хэмжээ:</u> Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцуулан, чадавхжуулах | 2021-2024 | ОНТ 5.5 | Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан ажилтны тоо /давхардсан тоогоор/ | 2022 | 250 | 300 | Соёл урлагийн дээд сургуульд 1 өвийн ажилтан, Соёл урлагийн их сургуульд 1 хөгжмийн багш суралцаж байна.<br>Мэргэжлийн чиглэлээр улс болон аймаг орон нутгаас зохион байгуулагдсан цахим болон танхимын 14 төрлийн сургалтад 19 байгууллагын давхардсан тоогоор 191 албан хаагч хамрагдлаа. | 100 |
| 2.5.2.2 | <u>Арга хэмжээ:</u> Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг орон сууцжуулах | 2022-2024 | ОНТ 2.5 | Орон сууцанд орох хүсэлт гаргасан ажилтнуудын шийдвэрлэлтийн хувь | 2022 | 50 | 70 | Орон сууцанд орох хүсэлт салбарын албан хаагчдаас ирээгүй. | 100 |
| 2.5.3 | <u>Зорилт</u>: Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 1431 байсныг 2024 онд 2587-д хүргэнэ. | 2021-2024 | ОНТ 839.5 | Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо | 2022 | 2000 | 2298 | Соёл, урлагийн салбарын 18 байгууллагаас цахим болон танхимын хэлбэрээр 1866 соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 3391 иргэн хамрагдсан. Музейн боловсролын хөтөлбөрт эрт галавын амьтан говь нутагт, Уламжлалт тоглоом наадгай VR технологиор шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдээ мэдээлэл болон дэлхийн хамгийн том амьтан, үлэг гүрвэл, Хар хориум хот, Монголын халуун рашаан, Нарны аймаг сэдвүүдийг музейн 30 ш үзмэрийг танилцуулсан. | 100 |
| 2.5.3.1 | <u>Арга хэмжээ:</u> Үндэсний бахархлыг шингээсэн шинэ уран бүтээлүүд туурвих | 2021-2021 | УТ ОНТ 12.0 | Шинээр туурвисан уран бүтээлийн тоо | 2022 | 7 | 8 | “Монгол түмнээ хүндлэн золгоё”, "Эрхэмсэг", “Хоймор дүүрэн хийморь”,“Эх түүхийг эргэцүүлэхүй” нэртэй шинээр болон шинэчилсэн 4 уран бүтээл туурвилаа. Уран | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүтээлийн зардалд орон нутгийн төсвөөс 16,1 сая төгрөг зарцуулсан. Хагас жилд төлөвлөсөн үр дүнд хүрсэн. | |
| | | 2021-2024 | | Тухайн жилд хүүхдэд зориулсан шинэ уран бүтээлийн тоо | 2022 | 2 | 2 | “Болдоггүй бор өвгөн” таягт хүүхэлдэйн жүжиг, “Жангарын 12 баатрын магтаал” нийт 2 уран бүтээлийг туурвиж цахим сайтад байршуулан олон нийтэд сурталчиллаа. Орон нутгийн төсвөөс 820.000 төгрөгийг зарцууллаа. | |
| 2.5.3.2 | <u>Арга хэмжээ:</u> Цэргийн ангийг түшиглэн "Үлээвэр хөгжмийн хамтлаг" байгуулах | 2023 | УТ ОНТ 2.0 | Хөгжмийн зэвсгийн хангалтын хувь | 2022 | | 100 | "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрт байсан 4,500,000 төгрөгийн өртөг бүхий 10 төрлийн үлээвэр найрал хөгжмийн зэмсгийг Зэвсэгт хүчний 065-р ангийн 278-р байгууламжийн бие бүрэлдэхүүнд хүлээлгэн өгсөн. | 50 |
| | | | | Үлээвэр хөгжмийн хамтлаг байгуулагдсан эсэх тийм-1, үгүй-0 | 2022 | | 1 | Орон тоо болон хөгжмийн зэмсгээр хангагдсан боловч хөгжимчин болох боловсон хүчин байхгүйн улмаас үлээвэр хөгжмийн хамтлаг байгуулагдаагүй. | |
| 2.5.3.3 | <u>Арга хэмжээ:</u> "Уяхан замбуу тивийн наран" уртын дуучид, морин хуурчдын эвент наадмыг зохион байгуулах | 2023 | | Эвент наадмыг зохион байгуулсан эсэх тийм-1, үгүй-0 | 2022 | | 1 | Хугацаа болоогүй | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ОНТ 15.0 | Шавь сургалтаар бэлтгэсэн авьяастны тоо | 2022 | | 3000 | Шавь сургалтыг эхний хагас жилийн байдлаар төлөвлөсөн 1730 морин хуурч, уртын дуучдаас 1985 авьяастныг бүртгэж, сумдад сургалтыг эхлүүллээ. Үүнээс 5 дугаар сарын байдлаар нийт 724 морин хуурч, уртын дуучин хүүхдийг бүрэн бэлтгэж, цахим бичлэг хийсэн. | 100 |
| 2.5.3.4 | <u>Арга хэмжээ:</u> Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах | 2021-2024 | УТ ОНТ 12.0 | Алдартан, гавьяатнуудын нэрэмжит болгон зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2022 | 4 | 6 | Зууны манлай алдарт уртын дуучин МУГЖ Ж.Дорждагвын нэрэмжит Хүүхдийн урлагийн бага наадам, МУГЖ Д.Баттөмөрийн нэрэмжит “Дуунд мөнхөрсөн нутаг”, Н.Лхагва-Очир агсны нэрэмжит Сэтгэлд мөнхөрсөн “Сийлэн бөөр" ардын болон зохиолын дууны уралдаан, 1939-1945 оны чөлөөлөх дайнд оролцож байсан ахмад дайчин Ч.Ишдовдон, Б.Зундуй нарын намтар, түүхийг харуулсан үзэсгэлэн, Сайнцагаан сумын 6, Хулд сумын 10, Өлзийт сумын 11 өвлөн уламжлагч нарын уран бүтээлийн цахим сурталчилгаа хийж нийт эхний хагас жилд 3 арга хэмжээ төлөвлөснөөс 5 арга хэмжээг зохион байгуулж, 80.6 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| 2.5.3.4.1 | **<u>Дэд арга хэмжээ:</u>** Уран үгсийн чуулган яруу найргийн наадам зохион байгуулах | | УТ ОНТ 10.0 | Яруу найргийн наадамд оролцогчдын тоо | 2022 | | 50 | Хугацаа болоогүй | - |
| 2.5.3.5.1 | <u>Дэд арга хэмжээ:</u> Музейн сан хөмрөгийг насжилт | 2021-2024 | УТ 5.0 | Баяжуулсан үзмэрийн тоо | 2022 | 21 | 29 | Музейн сан хөмрөгт хандиваар 5, цуглуулгаар 2, нийт 7 дэсийн 7 үзмэр нийт 27 ш үзмэрийг сан хөмрөгт | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өндөртэй эртний үзмэрүүдээр баяжуулах | | | | | | | баяжуулалт хийсэн. Гавьяат багш Цэвээнравдан багшид хадгалагдаж байсан дээд язгууртан хэрэглэж байсан шүүгээтэй, хуучин хятад бичигтэй толь, төв халх хийцийн уран дархнуудын бүтээлүүдийг сан хөмрөгийн баяжилтад судалж байна. | |
| 2.5.3.6 | Арга хэмжээ: Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сумын гэрээт хамгаалагчтай болгох | 2021-2024 | | Сумдын гэрээт хамгаалагчдын тоо | 2022 | 30 | 30 | 15 сумын улс аймаг, орон нутгийн хамгаалалттай 408 дурсгалт газрыг 197 малчинтай сайн дурын гэрээ байгуулсан. | 100 |
| 2.5.3.7 | Арга хэмжээ: Төвд номын фондыг шинээр үүсгэн байгуулах | 2021-2024 | ОНТ 3.0 | Баяжуулсан Төвд номын тоо | 2022 | 50 | 185 | Хугацаа болоогүй | - |
| 2.5.3.8 | Арга хэмжээ: "Бүрдийн уянга" хүүхдийн зусланг түшиглэн "Ардын зан үйл-амьдрах арга ухаан" хөтөлбөрт сургалтыг зохион байгуулна. | 2021-2024 | ОНТ 2.0 | Тухайн жилд зохион байгуулсан сургалтын тоо | 2022 | 4 | 4 | Бүрдийн уянга хүүхдийн зусланд 3 дугаар ээлж буюу 7 дугаар сард амралтын хүүхдүүдийг хүлээн авч үйл ажиллагааг Соёл урлагийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөн "Ардын зан үйл амьдрах арга ухаан" хөтөлбөрийг 5-н төрлөөр боловсруулан 850.000 төгрөгийн төсвийг хийгээд байна. | - |
| | | 2021-2024 | ОНТ 1.0 | Тухайн жилд хөтөлбөрт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо | 2022 | 400 | 400 | Хугацаа болоогүй | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.3.9 | <u>Арга хэмжээ:</u> Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх "Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч" төслийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулна. | 2021-2024 | ОНТ 2.0 | Зохион байгуулсан сургалтын тоо | 2022 | 18 | 19 | Дэлхийн хамгийн том амьтан", "Нарны аймаг", "Шагай хамах", "Танграм" тоглоом, "Монгол бахархал-өв соёл", "Музейн нээлттэй өдрүүд", "Баримтын үнэ цэнэ-өв соёл" үзэсгэлэн сурталчилгаа, "Уран зургийн үзэсгэлэн", "Музейн шилдэг 30 үзмэр" үзэсгэлэн, монгол өв соёл, ардын уламжлалт урлаг чиглэлээр уртын дуу, морин хуур, монгол бүжиг, хөөмийн сэдэвт сургалтуудыг хагас жилд төлөвлөсөн 10 сургалт сурталчилгаанаас хэрэгжсэн нийт 13 үзэсгэлэн сурталчилгаа, сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд танхимаар VR, AR технологи ашиглан зохион байгуулсан. | 97 |
| | | 2021-2024 | | Хамрагдсан хүүхдийн тоо | 2022 | 3500 | 4500 | Хүүхдүүдийн дунд зохион байгуулсан үзэсгэлэн сурталчилгаа, сургалтад хагас жилийн байдлаар 2119 хүүхэд хамрагдсан. | |
| **3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | |
| 3 | <u>Зорилго:</u> Аймгийн ДНБ 2019 онд 383383.01 сая төгрөг байгааг 2024 онд 513134.61 сая төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | | ДНБ-ний өсөлт (сая.төг) | 2022 | 448258.8 | 480696.71 | Хугацаа болоогүй. | - |
| **3.1 Санхүү, төсвийн зохицуулалт** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1. | Зорилго: Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын бааз 2020 онд 7697110.4 мянган төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлж, 2024 онд 8331600.0 мянган төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | | Татварын орлогын баазыг нэмэгдүүлсэн дүн (мян.төг) | 2022 | 8008074 | 8168235.1 | Татвар төлөгчид 100 хувь цахимаар татвар төлж байгаа бөгөөд 2023 оны эхний 4 сарын байдлаар 2.769.087,1 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө биелүүлэхээс 3.750.556,5 мянган төгрөгийн татварын орлогыг бүрдүүлсэн байна. Төлөвлөгөөний биелэлт 135.4 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 2.1 хувиар нэмэгдэж зорилтот түвшин хангасан. | 100 |
| 3.1.1 | Зорилт: Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалт 2020 онд 93.9 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ. | 2021-2024 | | Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулсан хувь | 2022 | 96 | 98 | Татварын бүх төрлийн тайланг цахимаар хүлээн авч татварын хураалтын түвшин 96 хувийн гүйцэтгэлтэй байна. | 95 |
| 3.1.1.1 | Арга хэмжээ: Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлэх | 2021-2024 | | Цахимаар ирүүлсэн тайлангийн хувь | 2022 | 88 | 91 | Татвар төлөгчийн татварын тайланг 100 хувь цахимаар хүлээн авч байна. Үүнээс:<br>1.Суутган-1 татварын тайлан 1124 татвар төлөгч ирүүлэхээс 948 нь буюу 84.3 хувь ,<br>2. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн 856 тайлан хүлээн авахаас 855 тайлан хүлээн авч 99.8 хувь,<br>3.Дотоодын архины онцгой албан татварын 3 тайлан хүлээн авахаас 3 тайлан хүлээн авч 100 хувь<br>4. Ашигт малтмал нөөц ашигласны төлбөрийн тайлан 57 тайлан хүлээн авахаас 53 тайлан хүлээн авч 92.9 хувь, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 19 тайлан хүлээн авахаас 19 тайлан хүлээн авч 100 хувьтай. Тайлант жилд нийт 2059 тайлан хүлээн авахаас 1878 тайлан хүлээн авч 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 3.1.1.2 | Арга хэмжээ: Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь биелүүлэх | 2021-2024 | | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2022 | 100 | 100 | 2023 оны эхний 4 сарын байдлаар төсвийн орлогын төлөвлөгөө 2769087,1 мянган төгрөг биелүүлэхээс 3750556,5 мянган төгрөг төвлөрч 135,4 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>1. Улсын төсвийн орлого 616818,1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 870519,8 мянган төгрөг төвлөрч 141,1 хувь<br>2. Аймгийн төсвийн орлого 176674.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 425568.1 мянган төгрөг төвлөрч 240 хувь<br>3. Сумын төсвийн орлого 2175595,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 2424511,9 мянган төгрөг төвлөрч 111,4 хувьтай. | 100 |
| 3.1.1.3 | Арга хэмжээ: Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг орон нутагт бүртгэлжүүлэн, татварын үйлчилгээг саадгүй хүргэж татварын бааз суурийг өсгөх | 2021-2024 | | Татвар төлөгчийн тоо | 2022 | 40022 | 40822 | 2023 оны 1-р улиралд шинээр 53 хуулийн этгээд, 456 иргэн бүртгэгдэж нийт 40531 татвар төлөгч бүртгэлтэй байна. Нийт 3 хувь өссөн байна. | 100 |
| 3.1.2 | Зорилт: Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, | 2021-2024 | - | Орон нутгийн ААН-ийн эзлэх хувь | 2022 | 35 | 40 | 2023 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17,2 тэрбум төгрөгийн 56 бараа, ажил, | 10 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтад орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2020 онд 30 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ. | | | | | | | үйлчилгээний төсөл, арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд хагас жилийн байдлаар үүнээс тендер шалгаруулалтаас 2, шууд худалдан авалтаас 1, нийт 3 төсөл арга хэмжээг буюу орон нутгийн аж ахуйн нэгжийг сонгож гэрээ байгуулсан байна. | |
| 3.1.2.1 | Арга хэмжээ: Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх | 2021-2024 | - | Нийт зарлагдсан тендерээс вэбсайт болон пейж хуудсанд урилга, үр дүнг нийтэлсэн тендерийн эзлэх хувь | 2022 | 100 | 100 | 2023 оны 5 дугаар сарын байдлаар зарлагдсан 41 тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлан зохион байгуулж урилга болон үр дүнг tender.gov.mn, dundgovi.gov.mn, газрын пэйж хуудсаар тухай бүр олон нийтэд хүргэн ажиллаж байна. | 100 |
| 3.1.2.2 | Арга хэмжээ: Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах | 2021-2024 | | А3 сертификаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтын тоо | 2022 | 1 | 2 | Худалдан авах ажиллагааны А3 сертификаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтыг 2023 оны 05 сарын 27-31-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 50 |
| | | 2021-2024 | | А3 сертификат эзэмшигчийн иргэдийн тоо | 2022 | 130 | 140 | Худалдан авах ажиллагааны А3 сертификаттай иргэдийн тоо 2023 оны 5 сарын байдлаар аймгийн хэмжээнд 214 иргэн болгож нэмэгдүүлээд байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3 | Зорилт: Төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж төсвийн ил тод байдал, сахилга батыг сайжруулж, шилэн дансны хэрэгжилт 2020 онд 91.3 байсныг 2024 онд 98 хувьд хүргэнэ. | 2021-2024 | | Шилэн дансны хэрэгжилтийн дундаж хувь | 2022 | 95 | 96 | 2023 оны 1-р улирлын байдлаар шинэчилсэн Шилэн дансны системээр орон нутгийн болон төсвийн байгууллага, ОНӨҮГ-ийн 142 байгууллага тогтоосон хугацаанд байршуулах нийт 6700 мэдээллээс 92,8 хувь буюу 6218 мэдээллийг хугацаанд нь 2,9 хувь буюу 197 мэдээллийг хугацаа хожимдуулан цахим сүлжээнд байршуулан мэдээлж, нийт мэдээлэх мэдээний гүйцэтгэл 95.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. | 95 |
| 3.1.3.1 | Арга хэмжээ: Эрсдэлд суурилсан дотоод аудитыг бэхжүүлж, төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | | Хяналт, шалгалт хийсэн тоо | 2022 | 80 | 70 | Засаг даргаар батлуулсан 2023 оны хяналт, шалгалтын төлөвлөгөө, нэгдсэн удирдамжаар нийт 71 нэгж, байгууллага шалгахаар батлуулж, эхний хагас жилээр төлөвлөгөөт 39 нэгж байгууллага, төлөвлөгөөт бус 2 нэгж байгууллага нийт 41 нэгжид хяналт шалгалтыг хийж шалгалтын тайланг бэлтгэн танилцуулсан. Үүнээс 10 нэгж байгууллагад дотоод аудит, 31 нэгж байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийгдсэн байна. | 100 |
| | | | | Мэргэшсэн дотоод аудиторын тоо | 2022 | 1 | 2 | Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд 2 албан хаагчийг дотоод аудитораар сургахаар тусгаж, сургалтад 6 дугаар сард хамрагдахаар төлөвлөсөн. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2022 | 86 | 88 | 2023 оны 5 дугаар сарын байдлаар шалгалтад хамрагдсан 7 байгууллага нэгж, өмнөх оны 2 байгууллага нийт 9 байгууллага нэгжийн 59 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцоход хугацаандаа ирүүлсэн 3 нэгж байгууллага, 1 байгууллага хугацаа хоцроож хэрэгжилт ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилт 86.8 хувьтай. | 90 |
| 3.1.3.2. | <u>Арга хэмжээ:</u> Төсөв захирагч нарыг чадавхжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | 2021 - 2024 | | Тухайн жилд зохион байгуулах сургалтын тоо | 2022 | 6 | 7 | Хугацаа болоогүй. | - |
| 3.1.3.3 | <u>Арга хэмжээ</u>: Төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг зохион байгуулж төрийн сангийн төлбөр тооцоог үе шаттайгаар цахимжуулах | 2021 - 2024 | | Цахимжуулсан байгууллагын тоо | 2022 | 10 | 136 | Төрийн сангийн удирдлагын цахим системийг нийт 169 байгууллагад нэвтрүүлж төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэж байна. | 100 |
| | **3.2 Уул уурхай, хүнд үйлдвэр** | | | | | | | | |
| 3.2.1 | <u>Зорилт:</u> Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2019 онд 647.5 сая төгрөг байгааг 2024 онд 2,648.0 сая төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | | Олборлох үйлдвэрлэлийн ДНБ-ний хэмжээ (сая.төг) | 2022 | 1647.5 | 2147.5 | Уул уурхайн олборлолт 2022 оны 4 дүгээр сард 3681.8 сая төгрөг байснаас 2023 оны 4 дүгээр сард 8047.6 сая төгрөг болж 218.6 хувиар өссөн байна. Боловсруулах үйлдвэрлэл 504.6 сая төгрөгөөс 612.1 сая төгрөг болж 231.4 хувиар өссөн байна. | 100 |
| 3.2.1.1 | <u>Арга хэмжээ:</u> Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийгмийн хариуцлагын | 2021-2024 | | Хамтран ажиллах гэрээний тоо | 2022 | 10 | 15 | Аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 121 талбай байгаагаас үйл ажиллагаа явуулахаар Байгаль | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээ 2020 онд 2 байсныг 2024 онд 18 болгон нэмэгдүүлнэ. | | | | | | | орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан 6 ААН байна. Уул уурхайн аж ахуй нэгж, аймаг, сум гэсэн гурвалсан гэрээг байгуулахаар гэрээний төсийг боловсруулан ажиллаж одоогоор 3 ААН 2023 оны хамтран ажиллах гэрээ байгуулахаар гэрээний төслөө хянуулан, саналаа ирүүлээд байна. Мөн ирэх 6 дугаар сарын 23-нд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компаниудын чуулганыг зохион байгуулахаар бэлтгэл хангган ажиллаж байгаа бөгөөд тус чуулганы үеэр ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ААН-тэй гурвалсан гэрээг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 3.2.1.2 | Арга хэмжээ: Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн зүгээс дэмжиж, ордын тодорхой хувийг орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэх | 2021-2024 | | Орон нутгаас ажиллаж буй иргэдийн тоо | 2022 | 60 | 63 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар “Эрдэнэс силвэр ресурс” ХХК-д орон нутгаас 66 хүнийг ажлын байраар хангаан ажиллаж байна. | 100 |
| | | 2023-2024 | | Орон нутгийн эзэмшилтэй болсон эсэх (Тийм-1, үгүй-0) | 2022 | - | 1 | Одоогоор шийдвэр гараагүй. | - |
| 3.2.1.3 | Арга хэмжээ: Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, "Дундговь аймгийн хөгжлийг дэмжих сан" байгуулах | 2021-2024 | | Хөрөнгө оруулалтын хэмжээ (сая.төг) | 2022 | - | 500.0 | Уул уурхайн аж ахуй нэгжтэй нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гурвалсан гэрээгээр ажиллаж байгаа бөгөөд энэ оноос Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн ОНХСанд төвлөрүүлэхээр тусгагдсан. Одоогоор төвлөрсөн мөнгөн дүн байхгүй. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
